

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЭХ СУМ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2020 оны 02 дугаар сарын 18

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДЭЛГЭРЭХ СУМ “ ГУДАМЖНЫ ГЭРЭЛТҮҮЛЭГ” АЖЛЫН  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

(ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА  
ХУДАЛДАН АВАХАД АШИГЛАНА)

Тендер  
шалгаруулалт/ гэрээний нэр:  
“Гудамжны гэрэлтүүлэг”

Тендер  
шалгаруулалт/  
гэрээний дугаар:/ХА/2020/02

Дорноговь аймаг, Дэлгэрэх сум  
2020 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Дорноговь аймгийн Дэлгэрэх сүм] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос [Гудамжны гэрэлтүүлэг] нийлүүлэх суурьлуулах тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг [2020 оны 02 дүгээр сарын 28-ний өдрийн 11:00]-аас өмнө [tender.gov.mn] хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан [2020 оны 02 дүгээр сарын 28]-ны өдрийн [11:30 минутанд]<sup>1</sup>-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорноговь аймаг Дэлгэрэх сүм  
Засаг даргын Тамгын газар  
Газрын даамал И.Болортuya  
Утас: **96671661**  
Засаг даргын орлогч Р.Сосорбарам  
Утас: **91103933**

<sup>1</sup> Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Гэрэлтүүлэг угсралтын ажлын <b>03.2.1, 0.4-10 Цахилгаан дамжуулах шугам, дэд станц угсралт, засвар түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ, Тусгай зөвшөөрлийн эх хувь гэрээний хамт</b></p> <p>Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараах нэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм эх хувь</li> <li>- Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан /АУДИТ-р баталгаажуулсан/ Эх хувь</li> <li>- Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудад тухай ажилтай ижил төстэй гэрэлтүүлгийн ажлыг тус бүр үндсэн гүйцэтгэгчээр гүйцэтгэсэн байх үүнээс сүүлийн нэг жил буюу 2019 онд төсөөт өртгөөс дээш дүнтэй гэрэлтүүлэг угсралтын ажил хийсэн байх, Тухай ажлыг нотлох бичиг баримт, Гэрээ, хүлээн авсан акт, Захиалагч, ашиглагч байгууллагын аль нэгний тухай ажил дууссан тухай тодорхойлолт ажил тус бүр дээр /эх хувь/</li> <li>- Түргэн хөрөөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ санал болгож буй үнийн дунгийн 100%-аас багагүй байх, Баталгаажсан зээлийн тодорхойлолт</li> <li>- Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого санал болгож буй үнийн дунгийн 100%-иас багагүй байх</li> <li>- Оролцогч компанийн танилцуулга</li> <li>- Ажлын зураг, тоо хэмжээний дагуу тооцсон төсөөтэй, эрх бүхий төсөөчнөөр баталгаажуулсан байна. /Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсвийн норм үнэлгээгээр тооцно/ <b>Зураг үнэ 800 000 тусгаж ирүүлэх</b></li> <li>- Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны график гарган баталгаажуулж ирүүлнэ.</li> <li>- Харилцагч банкны тодорхойлолт, Харилцдаг бүх банкны /өргүй байх/ Эх хувь</li> <li>- Татварын газрын тодорхойлолт, Цахим системээс авах/өргүй байх/ Эх хувь</li> <li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь</li> <li>- Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт Эх хувь</li> <li>- Авто тээврийн газрын тодорхойлолт</li> <li>- Гэрээг гүйцэтгэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл Үүнд: Цахилгааны инженер 1, ХАБЭА-н инженер 1, компанийн үндсэн ажилтан байна. Нотлох баримт ирүүлнэ. Иргэний үнэмлэх, дипломын хуулбар, НД-н дэвтрийн хуулбар ирүүлнэ. туслах ажилтан 3-аас дээш байх,</li> <li>- НД8 маяттыг 2019 оны 1 сараас 2020 оны 1 сар хүртэлх тайланг эх хувиар ирүүлнэ.</li> <li>- Машин механизм тоног төхөөрөмжийн судалгааны жагсаалтыг бодит байдлын фото зураг, холбогдох баримт бичгийн хамт ирүүлэх</li> <li>- Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд: Авто кран, Үйлчилгээний машин шат, цахилгааны төрөл бүрийн багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгсэлтэй байх</li> <li>- Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар, техникийн нэхцэлийн дагуу чанарын өндөр төвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>- Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, гаргацтай байх шаардлагатай.</li> <li>- ТШӨХ-д шаардсан материалыудын аль нэгийг ирүүлээгүй, Эх хувь гэсэндийг хуулбар ирүүлсэн тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно</li> <li>- Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл</li> <li>- Тодорхойлтууд нь тендер зарласан өдрөөс хойш авсан байна.</li> <li>- Баталгаат хугацааны албан бичиг ирүүлэх</li> <li>- Хийгдэх ажлын зураг зуран ирүүлэх ба хийгдэх ажлын Бодит зураг эрх бүхий этгээдээр баталгаажуулан ирүүлэх.</li> </ul>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p><b>Үнийн санал, тендерийн материалыг [2020 оны 02 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00]-аас өмнө [tender.gov.mn] хаягаар ирүүлнэ.</b></p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>[Дорноговь аймаг, Дэлгэрэх сум, Хонгор баг, ЗДТГазар ]</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>[Засаг даргын орлогчийн өрөө №4]</b></p> <p>Огноо: <b>[2020 оны 02 дүгээр сарын 28-ны өдөр]</b></p> <p>Цаг: <b>[11 цаг 30 минут]</b></p>
<b>ТӨӨЗ 2.3</b>	Энэ хэсэгт материал шаардахгүй.
<b>ТӨӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>[Дэлгэрэх сумын ГУДАМЖНЫ ГЭРЭЛТҮҮЛЭГ ажилд үнийн санал авна]</b>

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Барааны тодорхойлолт:

Д.Д	Загвар	Үзүүлэлт	Тоо хэмжээ
1	Хүний мэдрэмж	Бий, Тодорч, бүдгэрэх	
2	Замын гэрэлтуүлэг	Нарны эрчим хүчээр ажилладаг өөр дээрээ тольтой, гэрэлтуүлэг	
3	Шон	7 метр өндөртэй, 133-100-80 диаметртэй, Зузаан 4 мм багагүй байх	
4	Гадна гэрлийн шонгийн бетон суурь	50*50 харьцаатай 1,2 м багагүй гүн,	
5	Нарны хавтангийн чадал	18V40W	
6	Нарны батарейн баталгаа	5 жил	
7	LED гэрлийн наасжилт	50000 цаг	
8	Гэрэлтэлтийн өнцөг	120 градус	
9	Цэнэглэх хугацаа	6-7 цаг	
10	Ажиллах хугацаа	20 цагаас илүү	
11	Ажиллах температур (°C)	-20~+60	
12	CCT (k)	6500k-7000k	
13	Үйлдвэрийн баталгаа	2 жил	
14	LED дээд чадал	40W-50W	
15	Чимэглэл, 10-15 ватт лед гэрэл,	Шон бүрийн дээд талд гоёлын чимэглэл оруулж өгнө, Тусдаа нарны эрчим хүчээр хангагдах хүчин чадалтай, Дэнлуү хэлбэртэй	35
16	3 өнгийн цацуулагч	Ганддаггүй, Хуурдаггүй сайн чанарын Улаан, Шар, Цэнхэр өнгийн цацуулагчтай	
17	Баталгаат хугацаа	3 жил	

\*Хийгдэх шон, гэрэлтуүлгийн бодит зураг, техникийн тодорхойлолт хавсарган ирүүлэх, Үнэлгээнд харгалzan үзэх


\* Хийгдэх шонгийн хийцийн зураг хийлгэж эрх бүхий этгээдээр баталгаажуулж хавсаргах. Үнэлгээнд харгалzan үзэх.

**2.Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдэээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ

**3.Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн эрүүл ахуйн горимыг сахиж хайрцаг сав баглаа боодол эвдэрч хэмхрээгүй байх.]

**4.Бараа хүргэх газар:** [Барааг Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ЗДТГазар, бараа хүлээн авах комиссад]

**5.Бараа нийлуулэлтийн хуваарь:** [Барааг гэрээнд заасан хугацаанд ирүүлж суурилуулна ]

Боловсруулсан: Газрын даамал  И.Болортuya  
ЗДТГазрын дарга  Д.Гантэмэр

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮННИЙ САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг **[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу **[тоо]** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа Үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>   | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b>   | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |  |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>  | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.<br>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><p>Гэрээний үнийн дүнгийн <b>[too]</b><sup>2</sup> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p>   |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>3</sup></b>  | 9.1. Алданги оногдуулах хувь: <b>[1 Хувь]</b><br>Алдангийн нийт дүн: <b>[10 хувь]</b>  |

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

<sup>3</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>4</sup>

БАТЛАВ.

### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>5</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>4</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>5</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]